



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 6 сарын 06 өдөр

Дугаар 206

Улаанбаатар хот

Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 3.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1,246,593,600 /нэг тэрбум хоёр зуун дөчин зургаан сая таван зуун ерэн гурван мянга зургаан зуу/ төгрөгөөр нэмэгдүүлж, хавсралтад заасны дагуу өөрчлөлт оруулж, нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны бүртгэлд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 6 дугаар сарын 06 -ны өдрийн
106 тоот тогтоолын хавсралт



“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн үнэт цаасны
бүртгэлд орох өөрчлөлт

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны нэрлэсэн үнэ /₮/	Хувьцааны эхний үлдэгдэл			Өөрчлөлт		Хувьцааны эцсийн үлдэгдэл		
			Тоо ширхэг	Үнийн дүн /₮/	Эзлэх хувь	Тоо ширхэг	Үнийн дүн /₮/	Тоо ширхэг	Үнийн дүн /₮/	Эзлэх хувь
1	Сангийн яам	100	218,840,000	21,884,000,000	100	12,465,936	1,246,593,600	231,305,936	23,130,593,600	100
	Нийт		218,840,000	21,884,000,000	100	12,465,936	1,246,593,600	231,305,936	23,130,593,600	100